



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН  
ТУШААЛ

2016 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/177

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах  
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам"-ыг нэгдүгээр, "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэгний загвар"-ыг хоёрдугаар, "Дүрэмт хувцас, хэрэглэлийн эдэлгээний хугацаа"-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүрэмт хувцасны зардлыг жил бүрийн улсын нэгдсэн төсөвт тусгуулж ажиллахыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дарга /Д.Болд/-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын "Журам, загвар батлах тухай" 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/101 дүгээр тушаал, "Журамд, загварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/136 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.ДОРЛИГЖАВ

Хууль зүйн сайдын 2016 оны 05 дугаар  
сарын 30 ны өдрийн 17 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

**ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМТ ХУВЦАС, ЯЛГАХ ТЭМДЭГ  
ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагч /цаашид "Хяналтын улсын байцаагч" гэх/-ийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын дарга нь энэхүү журамд нийцүүлэн бусад албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам, байгууллагын таних тэмдэг /бэлгэдлийн загвар/-ыг баталж мөрдүүлнэ.

**Хоёр. Улсын байцаагчийн дүрэмт хувцасны төрөл, зориулалт**

2.1. Хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас нь ёслолын, өдөр тутмын, хээрийн гэсэн төрөлтэй, дулаан болон сэрүүний улирлын зориулалттай байна.

2.2. Ёслолын дүрэмт хувцсыг баяр ёслолын үйл ажиллагаа, хүндэтгэлийн болон гадаад, дотоод арга хэмжээнд оролцох, шагнуулах, албан тушаалд томилогдох үед өмсөнө.

2.3. Өдөр тутмын дүрэмт хувцсыг албан хаагч ажлын байр, албан үүрэг болон тусгайлан үүрэг даалгавар гүйцэтгэх, хөдөө орон нутагт ажиллах, хяналт шалгалт хийх бүхий л үед өмсөнө.

2.4. Хээрийн дүрэмт хувцсыг энэ журмын 2.3-т зааснаас гадна онцлог үүрэг даалгавар, дадлага, сургалт явуулах үед өмсөнө.

**Гурав. Дүрэмт хувцас**

3.1. Хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас дараах иж бүрдэлтэй байна:

3.1.1. малгай /ёслолын, берет, саравчтай, ноосон/;

3.1.2. китель, хүрэм /ёслолын, өдөр тутмын хар, харсаарал, хээрийн-хар, шаргал/;

3.1.3. цамц /срочка урт, богино ханцуйтай цамц, ёслолын, өдөр тутмын-цагаан, хар, хээрийн-шаргал, ноосон цамц /өдөр тутмын-хар, саарал-поло/

3.1.4. футболк /хар, шаргал/;

3.1.5. куртик /өвлийн/;

3.1.6. пальто /хар саарал/;

3.1.7. өмд, юбка /ёслолын, өдөр тутмын, хээрийн, өвлийн/;

3.1.8. тэлээ;

3.1.9. гутал /хагас түрийтэй өвлийн болон хавар, намрын/;

- 3.1.10. бээлий /хар, цагаан/;
- 3.1.11. бүс, агсамж /тоногтой суран бүсний иж, бүрдэл/;
- 3.1.12. зангиа.

3.2. Хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцасны ялгах тэмдэг:

- 3.2.1. жетон;
- 3.2.2. малгайн тэмдэг;
- 3.2.3. эвэр товч, шонхорын дүрс бүхий товч;
- 3.2.4. захны тэмдэг;
- 3.2.5. ханцуйн тэмдэг /хууль сахиулагчийн, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын таних тэмдэг/
- 3.2.6. албан хаагчийн нэрийн бичиглэл;
- 3.2.7. IMMIGRATION бичиглэл;
- 3.2.8. зангианы хавчаар.

**Дөрөв. Дүрэмт хувцас өмсөх**

4.1. Хяналтын улсын байцаагч нь албан үүрэг гүйцэтгэх бүх хүрээнд дүрэмт хувцасны иж бүрдлийг хангаж цэвэр, үзэмжтэй өмсөж хэрэглэнэ.

4.2. Хяналтын улсын байцаагч нь дүрэмт хувцас өмссөн үед Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын бусад ялгах тэмдэг бүхий жетон, ажлын үнэмлэхийг биедээ авч явна.

4.3. Хяналтын улсын байцаагч үйл ажиллагааны онцлогыг харгалзан тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийг шаардлагатай үед өмсөнө.

4.4. Малгай

4.4.3. саравчтай малгайг хавар, намар, зуны улиралд хээрийн дүрэмт хувцастай өмсөж хэрэглэнэ;

4.4.4. сэрүүний улиралд ноосон малгайны "IMMIGRATION" бичвэрийг зүүн хэсэгт байрлуулсан байдлаар хээрийн дүрэмт хувцастай өмсөнө;

4.4.5. малгайг өмсөхдөө саравч, ирмэгийг хөмсөгнөөс дээш 1 см-ийн зайтай тэгш өмсөнө;

4.4.6. ажлын байранд болон сургалт, хурал, зөвлөгөөний үед малгайгүй байж болно;

4.4.7. ёслолын малгайн саан сагалдаргыг малгайн хүрээний хоёр талын шонхорын дүрс бүхий жижиг товчинд товчлон тогтоож, малгайн тэмдэгний доод ирмэгийг дарж байрлуулна.

4.5. Китель, хүрэм, өмд, юбка

4.5.1. ёслолын кителийг албан хаагч нь энэ журмын 2.2-т заасан үйл ажиллагааны үед ёслолын саравчтай малгай, цамц, зангиа, өмд /юбка/, байгууллагын таних тэмдэг бүхий тэлээ, хар өнгийн гутал /ботинк, туфль/-тай өмсөнө. Дулааны улиралд кителийг хагас ханцуйтай цамцтай хослуулан өмсөж болно.

4.5.2. өдөр тутмын хар болон харсаарал өнгийн кителийг цагаан болон хар өнгийн цамц, берет малгай, зангиа, өмд /юбка/, байгууллагын таних тэмдэг бүхий тэлээ, хар өнгийн гутал /ботинк, туфль/-тай өмсөнө. Өдөр тутмын кителийг дулааны улиралд хагас ханцуйтай цагаан болон хар цамцтай хослуулан өмсөж болно.

4.5.3. хээрийн хүрмийг албан хаагч нь саравчтай малгай, хар өнгийн захгүй цамц /фудболк/, өмд, хагас түрийтэй хар өнгийн гутлын хамт хослуулан өмсөнө.

4.5.4. дулааны улиралд говийн аймгуудад шаргал өнгийн хээрийн дүрэмт хувцас, гутал өмсөж, хэрэглэж болно.

4.5.5. эмэгтэй албан хаагчийн юбоканы хормойн ирмэг нь өвдөгнөөс дээш 2 см-ийн зайтай байна;

#### 4.6. Цамц /срочка/, зангиа

4.6.1. срочкан цамцны зах нь ёслолын, өдөр тутмын кителийн захны түвшинд эсвэл дээш цухуйсан байдлаар, хар өнгийн зангиа, хавчаарын хамт өмсөж хэрэглэнэ;

4.6.2. дулааны улиралд богино ханцуйтай цамц /цагаан, хар/-ыг албан үүрэг гүйцэтгэх үедээ зангиагүйгээр өмсөж болно;

4.6.3. зангианд хавчаарыг зүүхдээ срочкан цамцны 4-5 дахь товчны хооронд байрлуулна.

4.6.4. хар болон саарал /поло/ өнгийн ноосон цамцыг китель өмсөөгүй үед болон эсхүл өдөр тутмын дүрэмт хувцастай хослуулан өмсөж болно;

#### 4.7. Куртик, пальто

4.7.1. өвлийн курткийг сэрүүний улиралд өдөр тутмын болон хээрийн хувцасны гадуур өмсөнө.

4.7.2. пальтог сэрүүний улиралд ёслолын болон өдөр тутмын дүрэмт хувцасны гадуур өмсөнө.

4.7.2. сэрүүний улиралд өвлийн курткийн юүдэнг малгайн гадуур давхар өмсөж болох ба юүдэн болон дотрыг салгаж өмсөж болно;

#### 4.8. Гутал

4.8.1. хар болон шаргал өнгийн хагас түрийтэй хавар, намрын болон өвлийн гутлыг хээрийн дүрэмд хувцсанд өмсөнө;

4.8.2. ёслолын болон өдөр тутмын хувцасны хамт хар өнгийн ботинк /туфль/ өмсөх бөгөөд хээрийн дүрэмт хувцсанд хагас түрийтэй /хар, шар/ гутал өмсөнө;

4.8.3. эмэгтэй албан хаагчийн гутлын өсгий 6 см-ээс илүүгүй байна.

#### 4.9. Бусад хувцас

4.9.1. захны тэмдгийг хээрийн хүрэм болон урт, богино ханцуйтай цамцны захны буланд хатгана;

4.9.2. дүрэмт хувцсанд хууль сахиулагчийн таних тэмдгийг баруун, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын таних тэмдгийг зүүн ханцуйнд байрлуулна;

4.9.3. байгууллагын таних тэмдэг бүхий тэлээг дүрэмт хувцасны өмдөнд бүсэлнэ;

4.9.4. тоногтой суран бүсний иж бүрдлийг хээрийн дүрэмт хувцасны гадуур тусгай хэрэгсэл агсах, биедээ авч явах зорилгоор бүсэлж хэрэглэнэ;

4.9.5. сэрүүний улиралд хар өнгийн савхин бээлий өмсөх ба цаг агаарын нөхцөл байдалд уялдуулан хар өнгийн илгэн, даавуун гадартай нэхий дотортой бээлий өмсөнө. Баяр, ёслолын арга хэмжээнд цагаан өнгийн бээлий өмсөнө.

4.9.6. дүрэмт хувцастай үед хар, хархөх өнгийн оймс, эмэгтэй албан хаагч хар ноосон өмд, эсхүл хар болон биеийн өнгөтэй трико, шилэн оймс өмсөнө.

2.5. Дүрэмт хувцасны иж бүрдлийн сольж өмсөх хугацаа, жигдрэлтийг иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын төвийн болон орон нутаг дахь нэгжийн дарга улирал, цаг үеийн байдлыг харгалзан шийдвэрлэж болно.

#### **Тав. Хориглох зүйл**

5.1. Дүрэмт хувцасны өнгө, загварыг өөрчлөх, өөр зориулалтын хувцсыг хооронд нь буюу энгийн хувцастай хольж өмсөх, дүрэмт хувцасны загвараас хасагдсан хувцас, ялгах тэмдгийг өмсөж хэрэглэх, дүрэмт хувцсыг бусдад шилжүүлэх, барьцаалах, худалдах;

5.2. Дүрэмт хувцсыг нөмрөх, энгэр задгай явах, этгээд хэлбэрийн болон тод өнгийн гутал, ботинк, оймс өмсөх, дүрэмт хувцсыг бүрэн бус өмсөж хэрэглэх /товч кноп бүрэн бус, цахилгаан эвдэрсэн, ханзарч урагдаж цоорсон/ гадаад орны цэргийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг, чимэг хэрэгслэл зүүх, дүрэмт хувцсанд элдэв нугалаа гарган индүүдэх;

5.3. Цамцыг өмд, юбканы гадуур тавьж өмсөх;

5.4. Юүдэнтэй хүрэм өмсөөгүй нөхцөлд дотортой өмдийг нь бусад хувцастай хамт өмсөх, хээрийн өмдний шуумгийг гутлын гадуур тавих, ботинктой өмсөх;

5.5. Хээрийн хувцсан дээр сročкан цамц өмсөж зангиа зүүх;

5.6. Эмэгтэй албан хаагчид нь үсээ задгай тавих;

5.7. хэт содон болон бусад тоноглолтой гутал өмсөх.

#### **Зургаа. Хүлээлгэх хариуцлага**

6.1. Албан хаагч энэхүү журамд заасныг биелүүлээгүй нь Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

Хууль зүйн сайдын 2016 оны 05 дугаар  
сарын 30 ны өдрийн 177 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

ИРГЭНИЙ ХАРЪЯАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧИЙН ДҮРЭМТ ХУВЦАС, ЯЛГАХ ТЭМДЭГНИЙ ЗАГВАР

### Нэг. Дүрэмт хувцасны бүрдэл

#### 1.1. Ёслолын дүрэмт хувцас:

- 1.1.1. ёслолын саравчтай малгай;
- 1.1.2. китель;
- 1.1.3. цагаан өнгийн сročкан цамц /урт болон богино ханцуйтай/;
- 1.1.4. зангиа;
- 1.1.5. тэлээ;
- 1.1.6. өмд, юбка;
- 1.1.7. пальто;
- 1.1.8. бээлий /хар, цагаан/

#### 1.2. Өдөр тутмын хувцас:

- 1.2.1. берет малгай /харсаарал/;
- 1.2.2. китель /хар болон харсаарал/;
- 1.2.3. цагаан, хар өнгийн урт болон богино ханцуйтай сročкан цамц;
- 1.2.4. зангиа;
- 1.2.6. тэлээ /төмөр/;
- 1.2.7. ноосон хүрэм, цамц /саарал-роло, харсаарал ноосон цамц/;
- 1.2.8. өмд, юбка /хар болон харсаарал/;
- 1.2.9. өвлийн хар өнгийн хүрэм /гадуур/
- 1.2.10. савхин бээлий /хар/

#### 1.3. Хээрийн /дулаан, сэрүүний улиралын/ хувцас:

- 1.3.1. саравчтай болон өвлийн ноосон малгай;
- 1.3.2. хүрэм /хар болон шаргал өнгийн/
- 1.3.3. захгүй цамц-фудболк /хар болон шаргал/
- 1.3.4. захтай ханцуйтай шаргал өнгийн цамц /говийн аймагт өмсөх/;
- 1.3.5. тэлээ /хар болон шаргал/
- 1.3.6. дулааны болон өвлийн өмд;

1.3.7. тоногтой суран бүсний иж бүрдэл;

1.3.8. өвлийн куртик;

1.3.9. савхин бээлий;

1.3.10. хагас түрийтэй /хар, шар/ гутал.

1.4. Говийн аймгуудад дулааны улиралд энэ журмын 1.3-т заасан хээрийн цайвар шаргал өнгийн дүрэмт хувцас өмсөж болно.

### **Хоёр. Дүрэмт хувцасны загвар**

#### **2.1. Малгай:**

2.1.1. ёслолын малгай нь мөнгөлөг саарал өнгийн саан сагалдарга, сагалдаргыг тогтоох зориулалттай малгайн хүрээний хоёр талд байрлах шонхорын дүрстэй хоёр жижиг товч, малгайн урд хэсэгт хүрээний доод ирмэгээс 0.5 см зайтай голлуулан байрлуулсан байгууллагын таних тэмдэг/төмөр/-тэй байна;

2.1.2. берет малгайн урд хэсэгт байгууллагын таних тэмдэг /төмөр/-ийг малгайн хүрээний дээд, доод ирмэгээс ижил зайд голлуулан байрлуулна;

2.1.3. саравчтай малгайн урд талд байгууллагын таних тэмдгийг, ар талд "IMMIGRATION", ноосон малгай зүүн талд "IMMIGRATION" бичиглэл цагаан өнгийн утсаар дүрслэгдсэн байна;

#### **2.2. Китель, хээрийн хүрэм, цамц, футболк**

2.2.1. өдөр тутмын харсаарал өнгийн дүрэмт хувцасны кителийн захыг нь тойруулан гаргасан мөнгөлөг цагаан өнгийн эмжээр, захны хэсэгт тариан түрүү бүхий дүрс, зүүн ханцуйнд "Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газар"-ын, баруун ханцуйнд "Хууль сахиулагч"-ийн таних тэмдэг, ханцуйн урд хэсэгт тойруулан гаргасан цагаан өнгийн алхан хээ, дүрэмт хувцсанд хадаж хэрэглэх мөнгөлөг өнгөтэй эвэр товчтой байна;

2.2.2. өдөр тутмын хар өнгийн китель, хээрийн хүрэм, шаргал өнгийн урт ханцуйтай цамц болон өвлийн куртикийн зүүн ханцуйнд "Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газар"-ын, баруун ханцуйнд "Хууль сахиулагч"-ийн таних тэмдэг, зүүн энгэрт "IMMIGRATION", баруун энгэрт албан хаагчийн нэрийн бичиглэлтэй байна;

2.2.3. ёслолын, өдөр тутмын урт болон богино ханцуйтай цамцны зүүн ханцуйнд "Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газар"-ын, баруун ханцуйнд "Хууль сахиулагч"-ийн таних тэмдэг, зүүн энгэрт "IMMIGRATION" бичиглэл;

2.2.4. өдөр тутмын хар болон саарал /поло/ ноосон хүрэм, цамцны болон зүүн энгэрт "IMMIGRATION", баруун энгэрт албан хаагчийн нэрийн бичиглэл;

2.2.5. захгүй цамц буюу футболкны зүүн энгэр болон ар талд "IMMIGRATION" бичиглэлтэй байна;

#### **2.3. Зангиа, тэлээ**

2.3.1. зангианд байгууллагын таних тэмдэг, "IMMIGRATION" бичиглэлийг цагаан өнгийн утсаар дүрслэнэ;

2.3.2. тэлээний арал дээр байгууллагын таних тэмдгийг дүрслэнэ;

#### **2.4. Ялгах тэмдэг**

2.4.1. малгайн тэмдэг, зангианы хавчаар, захны тэмдэгт байгууллагын таних тэмдэг, тариаг түрүү, "MONGOLIAN IMMIGRATION" гэсэн бичиглэл байна.

2.4.2. ёслолын малгайн товч нь шонхорын дүрстэй, дүрэмт хувцасны эвэр товч нь "MONGOLIAN IMMIGRATION" гэсэн бичиглэлтэй, хар, цагаан өнгийн хуванцар материалаар хийгдсэн байна;

2.4.3. жетон нь байгууллагын таних тэмдэг, хувийн дугаар бүхий мөнгөлөг саарал /төмөр/ өнгөтэй байна;

2.4.4. ханцуйн "Хууль сахиулагч" тэмдэг нь бамбай хэлбэртэй, дээд талд нь "ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ", доод талд нь "ХУУЛЬ САХИУЛАГЧ" гэсэн бичвэрийг кирилл үсгээр, гол хэсэгт бамбай дотор соёмбо, түүний хоёр талаар "МОНГОЛ УЛС" гэсэн бичвэрийг монгол бичгээр бичиж, тариан түрүүгээр хүрээлсэн байна;

2.4.5. ханцуйн "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар" тэмдэг нь бамбай хэлбэртэй, дээд талд "ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР", доод талд "MONGOLIAN IMMIGRATION" гэсэн бичиглэл, гол хэсэгт байгууллагын таних тэмдэг, түүний хоёр талаар "МОНГОЛ УЛС" гэсэн бичвэрийг монгол бичгээр бичсэн байна;

2.4.6. "Хууль сахиулагч", "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар" ханцуйн тэмдгийг дүрэмт хувцасны төрөл, материалын шинж чанарт зохицуулан хийх бөгөөд ёслолын, өдөр тутмын китель, хээрийн хүрэм, богино болон урт ханцуйтай цамцны ханцуйн дээд оёдлоос 5-10 см зайтай байрлуулна.

2.4.7. нэрийн болон IMMIGRATION бичиглэлийг хар өнгийн даавуун тасам дээр мөнгөлөг саарал өнгийн торгон утсаар хатгаж хийнэ.

#### Гурав. Дүрэмт хувцасны материалын шинж чанар

	Дүрэмт хувцас	Материалын шинж чанар
1	Ёслолын малгай	70% ноос, 30% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуу
2	Саравчтай малгай	70% хөвөн, 30% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуу
3	Ноосон малгай	40% ноос, 60% акрилийн холиотой, хар өнгийн утсаар нэхэж давхарлаж хийнэ
4	Китель, өмд, юбка	70% ноос, 27% полиэстрийн холиотой, 3% суналттай, хар болон харсаарал өнгийн даавуу
5	Хээрийн хүрэм, цамц, өмд	70% хөвөн, 30% полиэстрийн холиотой, хар болон шаргал өнгийн даавуу
6	Өвлийн куртик, өмд	100% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуугаар салдаг дотрыг нь зориулалтын дулаалгын материалаар хийнэ
7	Ноосон цамц	40% ноос, 60% акрилийн холиотой, хар болон харсаарал өнгийн утсаар нэхэж хийнэ. Ноосон цамцны мөр, тохойн хэсгийг даавуугаар давхарлана
8	Ноосон поло цамц	70% хөвөн, 30% акрилийн холиотой, хөвөн даавуу
9	Срочкан цамц	85% хөвөн, 12% полиэстрийн холиотой, 3% суналттай, хар

		болон цагаан өнгийн даавуу
10	Футболк	80% хөвөн, 20% полиэстрийн холиотой, хар болон шаргал өнгийн даавуу
11	Гутал /өвлийн/	хагас түрийтэй өнгийн гутлыг хар өнгийн арьсаар, хонины нэхий болон зориулалтын дулаалгын материалаар доторлоно
12	Гутал /хавар, намрын/	хагас түрийтэй хавар намрын гутлыг хар өнгийн арьсаар, зориулалтын материалаар доторлоно
13	Жетон, малгайн тэмдэг, зангианы хавчаар, товч, захны тэмдэг	мөнгөлөг саарал өнгийн төмрөөр хэвлэж хийнэ
14	Зангиа	хар өнгийн торгон материалаар хийнэ
15	Бээлий	хар өнгийн торгон савхиар хийнэ
16	Тэлээ	хар өнгийн зориулалтын ширээр, никель төмөр аралтай байна
17	Тоногтой суран бүс /агсамж/	хар өнгийн 5 мм-ийн зузаантай, зорулалтын ширэн, хоёр шүдтэй, никель төмөр аралтай байна

Хууль зүйн сайдын 2016 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 17 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН  
ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦАА

Д/д	Дүрэмт хувцас	Бүсийн ялгаа	
		Төвийн бүс /Ерөнхий газар, Буянт-Ухаа дахь газар/	Хангайн болон говийн бүс /Орон нутаг дахь газар/
1	Ёслолын болон өдөр тутмын малгайн тэмдэг	Хугацаагүй	Хугацаагүй
2	Ёслолын хувцас /китель, малгай, өмд, юбка, зангиа/	5 жил	5 жил
3	Ёслолын цамц	2 жил	2 жил
4	Ёслолын бээлий /цагаан/	2 жил	2 жил
5	Захны тэмдэг	10 жил	10 жил
6	Зангианы хавчаар	10 жил	10 жил
7	Пальто	7 жил	7 жил
8	Өдөр тутмын китель, өмд /юбка/	3 жил	2 жил
9	Ноосон цамц	3 жил	2 жил
10	Зангиа /өдөр тутмын/	2 жил	2 жил
11	Цагаан цамц /урт ханцуйтай/	1 жил	1 жил
12	Цагаан цамц /богино ханцуйтай	1 жил	1 жил
13	Хар цамц /урт ханцуйтай/	1 жил	1 жил
14	Хар цамц /богино ханцуйтай/	1 жил	1 жил
15	Хээрийн шаргал цамц	1 жил	1 жил
16	Бээлий /хар савхин/	2 жил	2 жил
17	Тэлээ	3 жил	2 жил
18	Жетон	Хугацаагүй	Хугацаагүй
19	Малгай /саравчтай, ноосон/	3 жил	2 жил
20	Хээрийн хүрэм, өмд	3 жил	2 жил
21	Захгүй цамц /футболк/	3 жил	2 жил
22	Ноосон цамц /поло/	3 жил	2 жил
23	Гутал /дотортой, доторгүй/	2 жил	2 жил
24	Өвлийн хүрэм, өмд	3 жил	2 жил
25	Тусгай хэрэгсэл	Тусгай хэрэгслийг үзүүлэлтээс нь хамаарч эдэлгээний хугацааг тодорхойлно.	